

ГАРЧИГ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	3
1.1. Төслийн ерөнхий мэдээлэл	3
1.2. Уурхайн ашиглалтын систем, ажиллах горим, техник тоног төхөөрөмж.....	5
1.3. Дэд бүтэц.....	7
1.4. Тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөө.....	8
ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ- ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	9
ГУРАВДУГААР БҮЛЭГ. ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ	12
3.1 Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тухай ерөнхий удирдамж.....	12
3.2 Төслийн болзошгүй сөрөг нөлөөлөл, үргэлжлэх хугацаа, эрчим	12
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	16
4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	17
4.2. Уурхайн нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	19
4.3. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	19
4.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө.....	19
4.5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	20
4.6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	20
4.7. Хог, хаягдлын менежментийн арга хэмжээний зардал.....	20
4.8. Тухайн жилийн орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр.....	21
4.9. Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө.....	22
4.10. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь	22

ХҮСНЭГТИЙН ГАРЧИГ

Хүснэгт 1. Төслийн товч танилцуулга.....	3
Хүснэгт 2. СЭ-0006А тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн солбицлын цэгүүд.....	3
Хүснэгт 3. Ашиглалтын технологийн элементүүд.....	5
Хүснэгт 4. Уурхайн ажиллах горим.....	6
Хүснэгт 5. Уурхайн уулын ажлын календарчилсан төлөвлөгөө.....	6
Хүснэгт 6. Унд ахуйн хэрэгцээний ус.....	7
Хүснэгт 7. Зам талбайн усалгаа.....	8
Хүснэгт 8. Болзошгүй болон гол сөрөг нөлөөлөл.....	12
Хүснэгт 9. Төслийн байршил, шийдэл, төлөвлөлт болон хэрэгжүүлэхтэй холбогдсон нөлөөллийн эрчим, үр дагаврыг магадлан жагсаах.....	14
Хүснэгт 10. Гол сөрөг нөлөөлөл.....	15
Хүснэгт 11. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардал.....	17
Хүснэгт 12. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	19
Хүснэгт 13. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	19
Хүснэгт 14. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө.....	19
Хүснэгт 15. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	20
Хүснэгт 16. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	20
Хүснэгт 17. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	20
Хүснэгт 18. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	21
Хүснэгт 19. Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө.....	22
Хүснэгт 20. Төслийн төлөвлөлт, биелэлтийг тайлагнах хуваарь.....	22

ЗУРГИЙН ГАРЧИГ

Зураг 1. Төсөл хэрэгжих талбайн байршилын зураг.....	4
--	---

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн ерөнхий мэдээлэл

Хүснэгт 1. Төслийн товч танилцуулга

№	Үндсэн үзүүлэлтүүд	Тайлбар
1	Төсөл хэрэгжүүлэгч байгууллага	“Силикат” ХК
2	Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг	Дархан-Уул, Дархан сум, 15-р баг, үйлдвэрийн район өөрийн байр Утас: 99113641
3	Төслийн нэр	Сайханы элсний ордыг ил аргаар ашиглах техник эдийн засгийн үндэслэл
4	Хүчинтэй хууль эрхзүйн баримт бичгүүдийн жагсаалт	Улсын бүртгэлийн гэрчилгээ: Улсын бүртгэлийн дугаар: 1910010007 Улсын регистрийн дугаар: 2050463 Улсад бүртгүүлсэн: 2006.10.13 Ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөл: Дугаар: СЭ-0006А Олгосон огноо: 2022.10.18
5	Ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлийн талбай	Талбайн хэмжээ: 59.25 га Газарзүйн солбицол: “Сайханы элс” –талбай: М-48-92
6	Ордын геологийн бодит (В+С) нөөц	Элс: 1748.76 мян.м ³
7	Ордын үйлдвэрлэлийн нөөц	Элс: 445.66 мян. м ³
8	Уурхайн жилийн хүчин чадал	Элс: 80.0 мян. м ³
9	Ордын ашиглалтын хугацаа	6 жил

Төслийн байршил: “Сайхны элс” талбай нь Улаанбаатар хотоос баруун хойш 230 км, Дархан хотоос 16 км зайд байрладаг.

Уг орд нь СЭ-0006А тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий 59.25 га талбайтай бөгөөд тусгай зөвшөөрлийн булангийн цэгүүдийн солбицлуудыг дараах хэсэгт харууллаа.

Хүснэгт 2. СЭ-0006А тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн солбицлын цэгүүд


№	Өргөрөг			Уртрөг		
	Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд
1	49	21	53.05	105	52	48.45
2	49	21	53.45	105	52	48.49
3	49	21	54.41	105	52	48.47
4	49	21	55.24	105	52	49.14
5	49	21	55.73	105	52	47.66
6	49	21	56.29	105	52	46.34
7	49	21	57.74	105	52	45.09
8	49	21	58.63	105	52	43.93
9	49	21	59.65	105	52	42.91
10	49	21	0.85	105	52	42.01
11	49	21	2.26	105	52	41.19
12	49	21	3.25	105	52	40.4
13	49	21	4.01	105	52	40.03
14	49	21	4.8	105	52	39.86
15	49	21	5.91	105	52	39.77
16	49	21	6.7	105	52	39.8
17	49	21	7.67	105	52	39.91
18	49	21	8.63	105	52	40.16
19	49	21	10.37	105	52	40.57
20	49	21	11.67	105	52	41.2

21	49	21	12.29	105	52	38.93
22	49	21	12.29	105	52	38.05
23	49	21	12.94	105	52	36.65
24	49	21	13.53	105	52	35.31
25	49	21	14.39	105	52	34.74
26	49	21	15.23	105	52	34.3
27	49	21	15.23	105	52	33.93
28	49	21	16.17	105	52	33.67
29	49	21	17.05	105	52	33.57
30	49	21	18.02	105	52	33.57
31	49	21	19.01	105	52	33.68
32	49	21	19.7	105	52	33.71
33	49	21	20.56	105	52	33.92
34	49	21	51.53	105	52	34.22
35	49	21	22.27	105	52	13
36	49	21	23.05	105	52	6.15
37	49	21	53.05	105	52	6.15
38	49	21	53.05	105	52	48.45



Төсөл хэрэгжих талбайн байршил

Сэлэнгэ аймаг, Сайхан сум, "Сайхны элс" нэртэй талбай



Зураг 1. Төсөл хэрэгжих талбайн байршлын зураг

1.2. Уурхайн ашиглалтын систем, ажиллах горим, техник тоног төхөөрөмж

1.2.1. Ашиглалтын систем, ажиллах горим

Уг орд нь хөрс хуулалтын зузаан нь 1.45-1.6 м, элсний зузаан нь 10.1–11.55 м байна. Уул-техникийн нөхцлийг харгалзан экскаватор автосамосвалын хослол ашиглан олборлолтын ажлыг хийж гүйцэтгэн элсний түр овоолго хүртэл тээвэрлэхээр төсөлд тусгалаа.

Хүснэгт 3. Ашиглалтын технологийн элементүүд

№	Үндсэн хэмжигдэхүүнүүд	Хэмжих нэгж	Утга
1	Олборлолтын ажлын доголын өндөр	м	5
2	Экскаваторын орлын хамгийн бага өргөн	м	11.6
3	Экскаваторын ажлын фронтын урт	м	30 ≤
4	Авто замын налуу	%	80-100
5	Авто замын өргөн	м	6
6	Замын тойруугын зөвшөөрөгдөх бага радиус	м	9.6

Үйлдвэрлэл явуулах үндсэн шийдэл

Ордын нийт нөөцийг А+В+С зэргээр 1748.76 мян.м³-ээр тооцжээ. Техник эдийн засгийн үндэслэлийг хийж гүйцэтгэхдээ захиалагч талын саналын дагуу олборлолтонд 1.3 м³ утгуурын багтаамжтай HYUNDAI 2900LC маркийн экскаватор ашиглан олборлолтын үйл ажиллагааг явуулахаар төслийг боловсрууллаа.

Уурхайн өдөр тутмын үйл ажиллагааг шуурхай удирдлагаар хангах, техник тоног төхөөрөмжийг засварлах, тэдгээрийг хадгалах, үйлчилгээ материал хангамжийг газар дээр нь зохион байгуулах үүднээс уурхайн дэргэд захиргаа аж ахуйн байгууламж барьж байгуулна.

Уурхайн бүрэлдэхүүнд дараахь объектууд орно. Үүнд:

Үйлдвэрийн объектууд:

- ✓ Сэлбэг хэрэгслийн агуулах,
- ✓ Дэд станц,
- ✓ Бусад байгууламжууд г.м

Туслах объектууд:

- ✓ Захиргаа аж ахуйн байр, хоолны газар /нарядны өрөө/,
- ✓ Ажилчдын амрах байр,
- ✓ Халуун усны байр,
- ✓ Машин тоног төхөөрөмжийн түр граж, засварын газар,
- ✓ Харуул хамгаалалтын байр,
- ✓ Бие засах газар,
- ✓ Хамгаалалтын хашаа г.м

Уурхайн түр тосгон нь тусгай сонгосон талбайд байрлах ба объектууд 24 цагийн турш харуул хамгаалалтанд байна. Ажилчдын байр, халуун усны байр, захиргаа аж ахуйн байрыг тохижуулсан контейнер ашиглан бүрдүүлнэ.

1.2.2. Уурхайн ажиллах горим.

Уурхайгаас элсийг олборлох, зөөвөрлөх, шигших зэрэг үндсэн үйл ажиллагаа нь өдөрт 1 ээлжээр, ээлжинд 8 цагаар ажиллана.

УУРХАЙ НЬ:

ЭЛС ОЛБОРЛОЛТ ► ТЭЭВЭРЛЭЛТ ► ТҮР ОВООЛГОД ХУРААХ ► БЭЛЭН БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ХЭРЭГЛЭГЧДЭД АЧИЖ НИЙЛҮҮЛЭХ ► гэсэн технологийн үндсэн горимын дагуу ажиллана.

Уурхай нь жил бүрийн 4 дүгээр сарын 01-нээс 10 дугаар сарын 31 хүртэл бүрэн ажиллах бөгөөд уулын ажил бусад үйл ажиллагаа нь дараах горимын дагуу явагдана.

Хүснэгт 4. Уурхайн ажиллах горим

№	Үндсэн ажиллагаа	Хэмжих нэгж	Үзүүлэлт
1	Үйлдвэрлэлийн бэлтгэл ажил	Хоног	15 (4.01-4.15)
2	Элс олборлон боловсруулах ажиллагаа	Сар	6 (4.16-10.31)
3	Хуанлийн өдөр	Хоног	214
5	Баяр ёслолын амралт	Хоног	7
6	Цаг агаарын хүндрэл	Хоног	12
7	Жилд ажиллах хоног	Хоног	180
8	Жилд ажиллах цаг	Цаг	1152
9	Хоногт ажиллах ээлж	Ээлж	1
10	Ээлжийн үргэлжлэх хугацаа	Цаг	8

Энд ажлын үргэлжлэх хугацаанд тохиолдох албан ёсны амралт, баяр ёслолын өдрүүдийг тооцон элс олборлох ажлын ажиллах хугацаа жилд 180 хоног болж байна.

1.2.3. Уурхайн хүчин чадал, календарь төлөвлөгөө

Хүчин чадлыг захиалагч компанийн техникийн даалгаварт тусгасаны дагуу 1.3 м³ утгуурын багтаамжтай Hyundai 2900LC маркийн экскаватор ашиглан олборлолтын үйл ажиллагааг явуулахад тус ордын элсийг 6 жилийн хугацаанд ашиглаж дуусахаар байна.

Ордын ашиглалтын явцад элсийг түр овоолгод хураана. Хураасан бүтээгдэхүүнийг утгуурт ачигч ашиглан хэрэглэгчдэд нийлүүлнэ.

Хүснэгт 5. Уурхайн уулын ажлын календарчилсан төлөвлөгөө

№	Үндсэн үзүүлэлтүүд	Ашиглалтын жилүүд						Нийт ашиглалтын хугацаанд
		1-р жил	2-р жил	3-р жил	4-р жил	5-р жил	6-р жил	
1	Элс олборлолт, мян.м ³	80.00	80.00	80.00	80.00	80.00	45.66	445.66
2	Хөрс хуулалт, мян.м ³	11.47	11.47	11.47	11.47	11.47	6.54	63.88
3	Нийт уулын цул, мян.м ³	91.47	91.47	91.47	91.47	91.47	52.20	509.54
4	Хөрс хуулалтын итгэлцүүр, м ³ /м ³	0.14	0.14	0.14	0.14	0.14	0.14	0.14
5	Олборлолтонд өртөх талбай, га	0.71	0.71	0.71	0.71	0.71	0.40	3.95

1.2.4. Уурхайн нээлт

Сайханы элсний ордын хайгуулын ажлаар тогтоогдсон ашигт давхаргын зузаан 10.1-11.55 м-т хэлбэлзэх байна. Хөрс хуулалт 1.45-1.6 м. Төсөлд уурхайн ажлыг эхлүүлэхдээ А'1 блокоос нээхээр төлөвлөлөө.

1.2.5. Уурхайн үндсэн тоног төхөөрөмж

Уурхайд өмнө ашиглагдаж байсан тоног төхөөрөмжүүдийг цаашид үргэлжлүүлэн ашиглахаар тооцлоо. Ухаж ачих ажилд 1.3 м³ утгуурын багтаамжтай Hyundai 2900LC маркийн экскаватор ажиллана.

Шимт хөрс хуулах ажлыг утгуурт ачигчаар гүйцэтгэж тээвэрлэлтэд автосамосвал ашиглана. Хөрсийг гадаад овоолгод байршуулах ба ашигт малтмалыг түр овоолго үүсгэх талбайд автосамосвалаар тээвэрлэн хүргэнэ. Автосамосвалын тээвэрлэлт хийх зайн нь дунджаар 500 м байна. Уурхайн дотоод тээвэрт Daewoo маркийн 25 тн даацтай автосамосвал ашиглана. Уурхайн олборлолтын ажилд ZL-50 маркийн 3 м³- ийн багтаамжтай утгуурт ачигч 2 ш байх шаардлагатай байна.

1.3. Дэд бүтэц

1.3.1. Цахилгаан хангамж

Үйлдвэрлэлийн үндсэн цахилгаан хэрэглэгчид нь ил уурхай, уурхайн тосгон байх болно. Мөн түүнээс гадна ашиглалтын туршид засварын газар, сэлбэг хэрэгсэлийн /материалын/ агуулах уурхайн тосгон зэрэг хэрэглэгчид 0.4 кВ – ын цахилгаан эрчим хүчээр хангагдана.

Сайханы уурхай нь 35/6 кВ-ын Хараа дэд станцын яч№15-аас тэжээлтэй 6 кВ-ын агаарын шугамын 84-р тулгуураас салбарласан “Түмэдийн нүүдэл” ХК-ийн эзэмшлийн агаарыг шугамын 33-р тулгуураас салбарлан 6 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам татан төвийн эрчим хүчний системд холбогдсон.

1.3.2. Ус хангамж

Усны эх үүсвэр

Уурхай нь технологийн усны хэрэгцээ байхгүй бөгөөд ахуйн хэрэгцээний усыг Силикат ХК-ийн үйлдвэрийн төвлөрсөн шугамаас зөөврөөр хангана.

Хүснэгт 6. Унд ахуйн хэрэгцээний ус

№	Үзүүлэлт	Норм	Хэмжээ	Хоног	Хоногийн усны хэрэглээ, м ³	Жилийн усны хэрэглээ, м ³
1	Унд ахуйн болон хэрэглээний ус	80 л/хоног	14 хүн	180	1.12	201.6
Нийт дүн					1.12	201.6

Замын урт 300 метр, өргөн 6 метр байна.

Хүснэгт 7. Зам талбайн усалгаа

№	Үзүүлэлт	Норм	Хэмжээ	Усалгаа хийх тоо	1 удаагийн усны хэрэглээ, м ³	Жилийн усны хэрэглээ, м ³
1	Зам талбайн усалгаа	2	1800 м ²	44	3.6	158.4
Нийт					3.6	158.4

Уг төсөл нь хоногт унд ахуйн болон зам усалгааны зориулалтаар 4.72 м³, жилд 360.0 м³ ус ашиглахаар байна.

1.4.Тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөө

2026 онд уулын ажлын календарчилсан төлөвлөгөөний дагуу 80.0 мян.м³ элс олборлон борлуулахаар төлөвлөсөн.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Физик газар зүй, байршил

“Сайханы элс” хайгуулын талбайд дахь “Сайхан” элсний орд нь Хараа голын баруун эрэг дээр Дархан-Уул аймгийн төв Дархан сум /хот/-оос баруун урагш 16 км зайд, засаг захиргааны хувьд Сэлэнгэ аймгийн Сайхан сумын нутагт оршино.

Уул зүйн тогтолцоо

Дүүрэг нь Хангай болон Хэнтийн уулсыг заагласан төв Монголын тэгш өндөрлөг дээр байршина. Орд нь хойд өргөрөгийн $49^{\circ}21'53,05''$ - $49^{\circ}23'14,74''$, зүүн уртрагийн $105^{\circ}51'39,04''$ - $105^{\circ}52'55,79''$ солбилцолд оршино.

Ордын ойролцоох өндөрлөгийн үнэмлэхүй цэгүүд 700-950 м дотор, мөн хөндийн татмын дээрх усан хагарал 200 м харьцангуйн өндөрт хэлбэлзэнэ. Талбайн дүүрэгт жижиг толгод, довхорхог гадарга зонхилох бөгөөд уул ба хадан цухуйц тэмдэглэгдсэн.

Ус зүй

Дүүргийн гол усны артери нь Хараа гол бөгөөд тус голын хөндий нь урт тэвш хэлбэртэй. Өргөн нь 3-7 м ба гүн нь гольдролын янз бүрийн хэсэгт 0.2 м-3.0 м хүртэл өөрчлөгдөнө. Голын урсгалын хурд 0.7-0.8 м/сек.

Голын гольдролын нам татам нь жил болгон хавар усаар дүүрдэг, голын гольдрол нь жигд биш өргөнтэй, өргөн нь 200 м-с ихгүй. Голын ус цуглуулах талбай 3-5 км бөгөөд нэгдүгээр дэнжийнх 1 км, хоёр дахь нь 5 км-ээс илүү гарна.

Хараа гол нь ихээхэн хэмжээний ус цуглуулах талбай буюу гольдрол, ус татмын 2 томоохон дэнжийг багтаана. Татам дээрх эхний дэнж ихэнхдээ зүүн эрэг дагуу үлдэгдэл /останцы/ хэлбэртэй байдаг. Дэнжийн мөрөгцөгийн өндөр нь татмын дээш 3-10 м.

Татам дээрх хоёр дахь дэнж зөвхөн Орхон гол, Хараа голын бэлчирт байна. Ордын дүүрэгт голын хөндийн татмын гадаргуу дээр нарийн элс бүхий доворхог сэрвэнгүүд их байдаг.

Уур амьсгал

Эрс тэрс уур амьсгалтай жилийн болон өдрийн хэмийн хэлбэлзэл ихтэй бүс юм. Нэгдүгээр сар жилийн хамгийн хүйтэн сар бөгөөд Хараа голын цаг уурын станцын өгөгдлөөр, дунджаар -27°C байдаг. Зарим өдрүүдэд -52°C хүрдэг. Өвөл дунджаар 55 хоног үргэлжилдэг ба -30°C хэмээс хүйтэн өдрийн тоо 23-30 хоног.

Өвөл хур тунадас ховор бөгөөд цас орсон ч бага хэмжээгээр ордог. Хавар 4 дүгээр сард эхэлдэг ба хэм гэнэт ихэсч их хүчтэй салхитай болдог. Хоногийн дундаж хэм 0°C -ээс дээш болох нь 4 дүгээр сарын 10-20-ны хооронд хэлбэлздэг.

Өвөл болоод зуны улирал дахь зонхилогч салхи нь өмнөд, зүүн өмнөд зүгийн салхи байна. Хаврын болон намрын улирал дахь зонхилогч салхи нь хойд, баруун хойд зүгийн салхи байна.

Салхины хурд өндөртэй дөрөв болон тавдугаар саруудад /3.9-4.0 м.сек/, харин салхины хурд багатай 12, 1, 2 дугаар саруудад / 1.3-1.6 м/сек / багтана.

Зун нь Монголын хойд хэсэгт үүлэрхэг ихтэй бага даралттай хур тунадасын хамгийн их улирал /70% орчим/. Зун 6 дугаар сарын дундуур эхэлдэг. Жилд агаарын дулаан +30°C хэмээс дээш өдрийн тоо 5-47 дотор хэлбэлзэнэ. Сарын дундаж хэм 0°C-ээс хасах хэм рүү 10 дугаар сарын хоёр дахь хагаст шилждэг.

Хөрс

Хөрсний улирлын хөлдөлтийн гүн нь 2-3 дугаар сард 2.8-3.0 м хүрдэг. Бага хэмжээний цасан бүрхүүл болоод агаарын нэлээд бага хэм нь өвлийн улиралд хөрс 2.9 м хүртэлх гүнд хөлдөх нөхцлийг бүрдүүлдэг байна.

Дөрөвдөгч сэвсгэр хурдсанд, ялангуяа, аллювийн гаралтай хурдсанд олон жилийн цэвдэг ажиглагдана. Олон жилийн цэвдэг нь 3.0 м гүнээс эхлэн ажиглагдаж 15-20 м хүртэлх гүнд тархана.

Голын хөндийд олон жилийн цэвдэг нь 5-20 см зузаан бүхий мөсөн давхарга байдлаар илэрнэ. Голын сав газрын дэнжийн шавранцар болон аллювийн гаралтай элсэнд цэвдэг нь “хуурай” байдлаар илрэх бөгөөд чулуулгийн ан цав болоод завсраар хяруу буух байдлаар илэрнэ. Жилийн хур тундасын дундаж хэмжээ 270 мм.

Хүн ам, эдийн засаг, зам харилцаа

Засаг захиргааны нэгжийн хувьд Сэлэнгэ аймгийн нутагт хамаарна. Монгол улсын үйлдвэрийн томоохон төв болсон Дархан хотоос баруун урагш 16 км-ийн зайд оршино. Хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд өмнө нь улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн элсний “Сайхан” нэртэй ордын тодорхой хэсэг хамаарагддаг бөгөөд бид тухайн ордын нөөцийн тодотгол тооцоог гүйцэтгэсэн болно.

1974 оны 7 дугаар сарын 14-ний өдрийн БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн №232 дугаар тогтоол ба МС ба ПСМ-ын 1974 оны 9 дүгээр сарын 5-ны өдрийн №4/2359 захиалгын дагуу Барилгын Материалын Экспедици “Сайхан”-ы элсний ашиглагдаж буй ил уурхайн дэргэдэх ордод нэмэлт хайгуул хийж, 1977 онд үр дүнгийн тайланг батлуулсан байдаг.

Тус аймаг нь зам, тээвэр, харилцаа холбоо, цахилгаан, дулааны эрчим хүч зэрэг дэд бүтцийн салбарууд сайн хөгжсөн үйлдвэрлэл, соёл боловсрол, шинжлэх ухааны томоохон

төв учраас гадаад орнуудын муж, хот, компани, хувь хүмүүстэй харилцаагаа өргөжүүлэн хөгжүүлж хамтран ажиллах хамгийн таатай нөхцөл бүрдсэн аймаг юм.

Дархан-Уул аймагт орчин үеийн технологи, техникээр бүрэн тоноглогдсон Мобиком, Скайтел, Юнител, Ж-Мобайл компаниудын салбарууд үүрэн телефоны, Миком Ситинет, Дархан нет, Цахим нет компаниуд интернетийн үйлчилгээ явуулдаг байна. Мөн Univision, Skymedia, Darkhan IPTV, DBS, ЛХА телевизүүдээр 24 цагийн турш дотоод гадаадын сувгуудыг үзэх боломжоор бүрэн хангадаг.

Дархан-Уул аймагт жижиг дунд, үйлдвэрлэл, үйлчилгээг эрчимтэй хөгжүүлж байна. Хувийн хөрөнгө оруулалтаар оёдол, архи спиртийн үйлдвэр, савхин эдлэл, талх нарийн боов, мах махан бүтээгдэхүүн зэрэг жижиг дунд үйлдвэрүүд болон банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо зэрэг аж ахуйн нэгж, байгууллагууд үйл ажиллагаагаа явуулж байна.

Дарханы орчим төмрийн хүдэр, нүүрс, шохой, доломит, хурдан хайлдаг элс, барилгын болон силикатын элсний орд зэрэг ашигт малтмалууд илрүүлэгдсэн. Барилгын материалын болон нүүрс, алт, төмрийн хүдрийн арвин их нөөцтэй аймаг юм.

Эдгээр байгалийн баялагтаа түшиглэн барилгын материалын үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлсэн бөгөөд Цемент, Силикат, Байшин үйлдвэрлэх комбинат, Архины үйлдвэр, "Керамзит", "Эрдэс хөвөн", "Төмөр бетоны" үйлдвэр, "Хүнсний үйлдвэр", "Нэхий Эдлэлийн үйлдвэр", "Мах комбинат", "Хар төмөрлөгийн үйлдвэр" зэрэг олон үйлдвэрүүдтэй.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

3.1 Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тухай ерөнхий удирдамж

“Силикат” ХК-ийн “Сайхны элс” нэртэй элсний ордыг ил уурхайн аргаар ашиглах төслийн хувьд байгаль орчны төлөв байдал, байгаль орчны эрх зүйн байдал зэрэг нь байгаль орчныг хамгаалах асуудалтай хэрхэн уялдах, төслийн үйл ажиллагаанаас хамрах нутаг дэвсгэрийн орчны бүрдэл хэсгүүдэд төслийн хэрэгжих үе шат бүрийн үйл ажиллагааны нөлөөлөл, түүнчлэн төслийн гол нөлөөллийг үнэлэн тогтоов.

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг Монгол улсын Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, байгаль орчны эрх зүйн баримт бичгүүдэд тулгуурлан магадлан жагсаах, давхцуулан зураглах, загварчлалын арга, харьцуулсан судалгааны арга БОНХЯ-аас /хуучин нэрээр/ гаргасан Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний аргачилсан заавар /2014/, байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд өргөн хэрэглэгддэг матриц зэргийг ашиглан хийж гүйцэтгэлээ.

3.2. Төслийн болзошгүй сөрөг нөлөөлөл, үргэлжлэх хугацаа, эрчим

Хүснэгт 8. Болзошгүй болон гол сөрөг нөлөөлөл

Байгаль орчны үзүүлэлт	Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцаггүй нөлөөлөх	Хүчтэй	Дунд зэрэг	Бага зэрэг
1. Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт										
Газрын доорх урсацын өөрчлөлт										
Газрын доорх усны чанарын өөрчлөлт										
Гадаргын усны өөрчлөлт										
Агаарын чанарын өөрчлөлт	x			x			x		x	
Ургамлын бүтцийн өөрчлөлт	x			x			x		x	
Хөрсний элэгдэл, эвдрэл	x				x		x		x	
Геологийн тогтоцын өөрчлөлт	x				x		x		x	
Зэрлэг амьтдын орон зай		x		x			x			x
Уур амьсгалын (бичил) өөрчлөлт										
2. Байгалийн нөөц, ашиглалт										
Газрын гадаргын нөөц баялаг										x
Бэлчээрийн байдал	x	x			x		x		x	
Эрдэс түүхий эдийн нөөц	x				x		x	x		
Эрчим хүчний нөөц										
3. Байгаль, орчны өөрчлөлт										
Ундны усны чанар, хэмжээ				x		x				
Урсгал усны хэрэгцээ										
Агаарын бохирдол	x			x			x		x	
Хөрсний эвдрэл, бохирдол	x				x		x		x	

4. Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор									
Байгалийн үзэсгэлэнт өнгө төрх өөрчлөгдөх	x			x			x		x
Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх	x				x		x		x
Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх									
Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх									
Археологи, палеонтологийн олдворт нөлөөлөх									
5. Эдийн засаг, нийгмийн асуудал									
Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх	x				x		x		x
Орон нутгийн орлого нэмэгдэх	x				x		x		x
Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох	x				x		x		x
Ажлын байр нэмэгдэх	x				x		x	x	
Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	x				x	x			x
Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх		x		x			x		x
6. Бусад нөлөөлөл									
Шороон зам, шилжилтээс болж хөрс эвдрэх	x			x	x	x			x
Ахуйн хаягдал, хогийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, шавьж үржих	x			x		x			x
Хүчтэй салхи, уруйн үер	x			x			x		x
Дүн	18	3	0	10	11	4	17	2	13
	6								6

Дээрх хүснэгтээс дүгнэхэд байгаль орчинд нөлөөлж болзошгүй шууд, урт хугацааны, буцалтгүй, дунд зэргийн нөлөөлөл нилээд хувийг эзэлж байна.

Үүнд:

- ✓ Агаарын чанарын өөрчлөлт
- ✓ Ургамлын бүтцийн өөрчлөлт
- ✓ Хөрсний элэгдэл эвдрэл
- ✓ Уур амьсгалын өөрчлөлт
- ✓ Агаарын бохирдол
- ✓ Хөрсний элэгдэл, бохирдол
- ✓ Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх
- ✓ Орон нутгийн орлого нэмэгдэх
- ✓ Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох
- ✓ Ажлын байр нэмэгдэх
- ✓ Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх
- ✓ Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх
- ✓ Шороон зам, шилжилтээс болж хөрс эвдрэх
- ✓ Ахуйн хаягдал, хогийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах шавьж үржих зэрэг байна.

Дээрх болзошгүй нөлөөллүүдээс харахад эдийн засаг, нийгмийн асуудалд уурхайн үйл ажиллагаа шууд, урт хугацааны, буцалтгүйгээр нөлөөлөх эерэг нөлөөтэй байна.

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг тогтоох зорилгоор шинжээчдийн хэсэг газар дээр нь очиж, төсөл хэрэгжих талбай болон орчны байдал, ТЭЗҮ-тэй танилцаж, холбогдох судалгааг хийсэн болно.

Төслийн болзошгүй нөлөөллийг тогтоохдоо *магадлан жагсаах* аргыг ашиглаж, үр дүнг дараах хүснэгтэд үзүүлэв. Энэ арга нь төсөл хэрэгжих үед тухайн нөлөөлөл байгаа эсэх дээр тулгуурладаг ба хэрэв тухайн нөлөөлөл байвал "х"-ээр тэмдэглэдэг.

Уг төслийн байршил, техник технологийн шийдэл болон төсөл хэрэгжих үеийн байгаль орчны асуудлыг тусад нь авч үзэн “магадлан жагсаалт” хүснэгтэнд түүний нөлөөллийн үр дагаврыг “муу”, “дунд”, “сайн” гэсэн утгуудын аль тохирохыг “х” гэж бөглөв.

Хүснэгт 9. Төслийн байршил, шийдэл, төлөвлөлт болон хэрэгжүүлэхтэй холбогдсон нөлөөллийн эрчим, үр дагаврыг магадлан жагсаах

Байгаль орчны асуудлууд	Нөлөөлөл байхгүй	Гол үр дагавар		
		Муу (бага)	Дунд	Сайн (их)
Төслийн байршилтай холбоотой байгаль орчны асуудал				
Хүн амыг нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой асуудал	х			
Түүх соёлын дурсгалт газар, археологи-палентологийн олдворт газрыг эвдэхэд хүрэх	х			
Усан хангамж, газрын доорх усны горимд өөрчлөлт орох	х			
2. Төслийн шийдэл, төлөвлөгөөтэй холбоотой байгаль орчны асуудал				
Үйл ажиллагааны болон ашиглалтын чанар нь тухайн орон нутагт нийцтэй эсэх, орчны бохирдлын хяналтын сонгосон төхөөрөмж хир зэрэг зохимжтой				х
Үйлдвэрлэлийн осол, мэргэжлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх болон ажилтнуудыг хорт хий, гал түймрээс хамгаалах асуудал хир зэрэг төлөвлөгдсөн			х	
Уурхайн үйл ажиллагааны явцад гарах тоосжилтыг бууруулах асуудал хир зэрэг тусгагдсан				х
Тусгай анхаарал тавих шаардлагатай хорт хий, тоос, утаа гардаг эсэх	х			
Үйл ажиллагааны үед гарах дуу чимээг багасгах талаар төсөлд тусгагдсан эсэх		х		
3. Барилга байгууламж барих, үйлдвэрийн аюулгүй ажиллагаатай холбогдож гарах байгаль орчны асуудал				
Төслийн үйл ажиллагааны үед усны нөөц хомсдох байдал		х		
Төсөл хэрэгжих үеийн хөрсний элэгдэл, эвдрэл				х
Үйлдвэрлэлийн осол, аваар, хортой нөхцөл үүсэх, халдварт өвчин гарах нөхцөл			х	
4. Төсөл хэрэгжүүлэх үеийн байгаль орчны асуудал				
Төслийн үйл ажиллагааны болон ашиглалтын чанарын талаарх төлөвлөгөө, санхүүжилт хир зэрэг бодитой, шаардлага хангасан эсэх			х	
Мэргэжлээс шалтгаалах өвчин болон аюулгүй ажиллагааны төлөвлөгөө, санхүүжилт бодитой эсэх			х	
Хөрсний эвдрэл, элэгдлийг бууруулах, орчныг тохижуулах асуудал төлөвлөгөөнд хэрхэн тусгагдсан (хөрсжүүлэх, ургамал тарих, зүлэгжүүлэх, талбайн усалгаа)			х	
Шуурхай хяналтын асуудал (төсөлд шуурхай хяналтын хугацаа, мөнгө зардал тусгагдсан эсэх)		х		
5. Төслийн ерөнхийд нь хянаж үзэх шалгуурууд (бодлогын чанартай асуудлууд)				
Төслийн техник технологийн шийдлийг техник эдийн засгийн хувьд болон хувилбараас авч үзэн аль болох оновчтой аргыг сонгосон эсэх асуудал				х

Төслийн байршилтай холбогдох нөлөөлөл

Төсөл хэрэгжих байршлын хувьд хүн амыг нүүлгэн шилжүүлэх, түүх соёлын археологийн олдворт газарт ямар нэгэн нөлөөлөл байхгүй.

Төслийн шийдэл, төлөвлөгөөтэй холбоотой асуудал

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх болон ажилтнуудыг хорт хий, гал түймрээс хамгаалах асуудал, мөн үйл ажиллагаанаас гарах дуу чимээг багасгах талаар дунд зэргийн үр дагавартай байна.

Төслийг хэрэгжүүлэх үеийн байгаль орчны асуудал

Төслийг хэрэгжүүлэх нийт ажлын явцад байгаль орчинд хөрсний элэгдэл эвдрэл, газар ашиглалтанд хохирол учруулах зэрэг нөлөөлөл хүчтэй байна.

Хүснэгт 10. Гол сөрөг нөлөөлөл

№	Байгаль орчны хүчин зүйлс	Гол сөрөг нөлөөлөл
1	Газрын гадарга, хөрс	Уурхайн үйл ажиллагаа болон овоолгоор хөрс, ургамал нь бүр мөсөн устаж, дахин сэргээгдэхгүйгээр үхжинэ.
2	Агаар	Элс ачих, тээвэрлэх, овоолго үүсгэх зэрэг үйл ажиллагааны үед агаарын чанарт үзүүлэх нөлөө их байна. Энэ үед тоос, тээврийн хэрэгслээс гарах ШТМ-ын утаа агаарт дэгдэж сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.
3	Гадаргын ус	Элс ачих, тээвэрлэх, овоолго үүсгэх зэрэг үйл ажиллагааны үед гадаргын ус тоосонцороор бохирдож болошгүй бөгөөд бүтээгдэхүүн тээвэрлэлтийн үед голын голидрол өөрсчлөгдөх эрсдэлтэй. Бүтээгдэхүүн тээвэрлэлтийн замын маршрут гарган батлуулж зөвхөн тээвэрлэлтийн замаар зорчих шаардлагатай.
4	Ургамал	Нийт талбайн ургамлан бүрхэвч устаж үгүй болно. Нөхөн сэргээгдэх байдал хязгаарлагдмал. Овоолго үүсгэх газрын ургамал мөн устаж үгүй болж ургамлын бүрхэвчийн хэмжээ, бэлчээрийн талбай багасна. Ургамлын нөхөн сэргээгдэх боломжийг судалж, хаягдал хаягдаагүй хэсгүүдийг нөхөн сэргээх шаардлагатай.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилго.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах, арилгах, төсөл хэрэгжих орчинд үүсэж болзошгүй сөрөг үр дагаврыг тогтмол хянах зорилготой. Тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөөр дараахь арга хэмжээг хэрэгжүүлэхийг зорино.

Үүнд:

- ✓ Уурхайн үйл ажиллагаанд хамрагдаж байгаа талбайн хэмжээнд байгаль орчны хуулийн нийцлийг хангах,
- ✓ БОННҮнэлгээний заалтуудыг хэрэгжүүлэх,
- ✓ Байгаль орчны төлөвлөгөөг хэрэгжүүлэх хамаарал, хамрах хүрээг тодорхойлох,
- ✓ Уурхайн үйл ажиллагаанд оролцогч байгууллагуудын үйл ажиллагаандаа баримтлан хэрэгжүүлэх байгаль орчны асуудлыг шийдвэрлэх арга хэмжээг тодорхойлох,
- ✓ Орон нутагтай байгаль хамгаалах, дүйцүүлэн хамгаалах ажилд хамтран ажиллах,
- ✓ Талуудын оролцоог хангах, ОХШХ-т олон нийтийн оролцоог хамруулах, тайлагнах тогтолцоог сайжруулах,

4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 11. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардал

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян. төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Агаар орчин									
1	Уурхай орчимд тоосжилт үүсэх	Уурхайн ам орчимд болон тээврийн гол замыг чийгшүүлэх, услах, дагтаршуулах	Уурхайн гол болон тээврийн зам	км	50.0	0.5	25.0 x 40 удаа = 1 000.0	Зуны хуурай улиралд 7 хоногт 2 удаа	MNS 4585:2007” “Гадаад орчны агаарын түгээмэл бохирдуулагчийн хүлцэх агууламж болон зөвшөөрөгдөх түвшин стандарт MNS 5916:2008
2		Жил бүрийн орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу агаар, орчин дахь тоосны хэмжээг тодорхойлж байх	Уурхай орчим, тээврийн гол зам дагуу	ОХШХ-ийн зардлаас				Жилд 2 удаа	
Гадаргын ба газрын доорхи усны нөөц									
1	Ашиглаж буй усны чанар муудах, хүрэлцээ бага байх	Унд, ахуйн хэрэглээний усанд тогтмол шинжилгээ хийлгэж байх	Хэрэглэж буй ундны уснаас	ОХШХ-ийн зардлаас				Улиралд 1 удаа	Усны тухай хууль, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль “Усан орчны чанарын үзүүлэлт” MNS 4586:1998.
Хөрсөн бүрхэвч									
1	Уурхайн замын ачааллаас хөрс элэгдэж, эвдрэлд орох	Хүнд машин механизм явах замыг засаж сайжруулан, байгалийн хөрс бүхий замаар тээвэрлэлт аль болох бага хийх	Уурхай орчим, тээврийн гол зам дагуу	Ашиглалтын зардлаар				Улиралд 2 удаа	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай Монгол улсын хууль MNS 5914:2008 “Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. MNS 5916:2008 “Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт”

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян. төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Ургамлан нөмрөг									
1	Уурхайгаас олборлосон элсийг шигшин ангилах ажлын үед ургамал устах, дарагдах, талхлагдах зэргээр хамгийн их нөлөөлөлд өртөнө.	Нөхөн сэргээлтэнд ашиглах хөрсний шимт хэсгийн овоолгыг стандартын дагуу тусгайлан овоолж, салхинд хийсэхээс хамгаалах.	Шимт хөрс, овоолгын талбай		Ашиглалтын зардлаар			Ашиглалтын явцад	MNS 5916:2008 Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт. Хадгалалт MNS5918:2008 Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн ерөнхий шаардлага
2		Уурхайн нөлөөллийн бүсэд хээрийн судалгаа хийж ургамлын бичиглэл хийх	Уурхайн нөлөөллийн бүс		ОХШХ-ийн зардлаар			6-7-р сард	БОННУ-ний тайлан
3	Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд оролцож мод тарих	Уурхайн талбай орчимд	ш	5.0	200	1 000.0	10-р сард	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн
Амьтны аймаг									
1	Амьтны аймагт хохирол учруулах, тоо толгой хорогдох, идэш тэжээлийн хомсдол үүсэх	Мал амьтан өнгөрч гардаг хэсгүүдэд тэмдэг, тэмдэглэгээ байрлуулах, Авто машины хурдыг тогтоосон хязгаарт байлгах	Үйл ажиллагааны турш		Ашиглалтын зардлаас			2026 онд	Амьтны тухай хууль: 6.1.3.амьтны хэвийн өсөлт үржилтийг хадгалах, тархац нутгийг хамгаалах, нүүдлийн замыг чөлөөтэй байлгах; 6.1.7.үйлдвэрлэл, аж ахуйн үйл ажиллагааны явцад амьтан устахаас урьдчилан сэргийлэх;
2026 оны байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний зардлын урьдчилсан дүн				2 000.0					

4.2. Уурхайн нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Хүснэгт 12. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Техникийн нөхөн сэргээлт	Нөхөн дүүргэлт	га	0.9	Үйл ажиллагааны зардлаар		2026 онд	MNS 5917:2008
2	Биологийн нөхөн сэргээлт	Биологийн нөхөн сэргээлтийн ажил төлөвлөгдөөгүй болно.						“Уул уурхайн үйлдвэрийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт” стандартууд
3	Таган буулгах, хаалтад бэлтгэх	-	-	-	-	-	-	-

4.3. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 13. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх	Мод тарих	Уурхайн талбай орчимд зурвас үүсгэн тариалах	100	5 000.0		2026 онд	-

4.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 14. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

№	Нөлөөлөлд өртөх иргэд	Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2026 онд нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээ төлөвлөгдөөгүй.							

4.5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 15. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Нөлөөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Археологийн дурсгал		Уурхай орчимд археологийн дурсгал				илрээгүй болно.	
2	Палеонтологийн дурсгал		Уурхай орчимд палеонтологийн дурсгал				илрээгүй болно.	

4.6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 16. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Гал түймэр	Галын булан байрлуулах	Уурхайн тосгон				2026 онд	MNS 6576 : 2016 Гал түймэртэй тэмцэх. Гал түймэр унтраах даралтын хоолой. Техникийн шаардлага Ил уурхайн аюулгүй ажиллагааны нийтлэг дүрэм
		Аваар устгах төлөвлөгөө боловсруулах	Уурхай	1		Үйл ажиллагааны зардлаас		
Нийт								

4.7. Хог, хаягдлын менежментийн арга хэмжээний зардал

Хүснэгт 17. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ахуйн	Хог хаягдлыг түр хадгалах цэгийг тохижуулах	Уурхай	ш	800.0	1	800.0	4-р сар	Хог хаягдлын тухай хууль
		Хог хаягдлын гэрээ байгуулж, тогтмол тээвэрлүүлэх	Уурхай	сар	100.0	7	700.0	4-10-р сар	
Нийт							1 500.0		

4.8. Тухайн жилийн орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр

Хүснэгт 18. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хяналт-шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Зардал, мян.төг/жил	Баримтлах стандарт ба арга, аргачлал
Агаарын чанар				
SO ₂ , NO ₂ , CO, Тоос,	Уурхайн гол зам орчим 3 цэгт	Жилд 2 удаа, хавар, намар	300.0	MNS 4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
Агаар бохирдуулагч бодисуудын ялгарлын хэмжээ	Ашиглагдаж буй тээврийн хэрэгслүүд	Жилд 1 удаа	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардлаас	MNS 5013:2003 Бензин хөдөлгүүртэй автомашин, утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга MNS 5014:2003 Дизель хөдөлгүүртэй
Дуу шуугиан				
Дуу шуугиан, чичиргээ	Уурхайн талбай, ажлын байранд 3 цэгт	Жилд 2 удаа, хавар, намар	200.0	MNS4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 5002:2000 Шуугианы норм, аюулгүй ажиллагаа
	Авто тээврийн зам дагуу	Жилд 2 удаа, хавар, намар		MNS4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
Хөрсөн бүрхэвч				
Хөрсний нефть бүтээгдэхүүний бохирдол	Уурхайн гол зам орчим 2 цэгт	Жилд 1 удаа	300.0	MNS 3473:1983 Газар. Газрын эдэлбэр. Газар ашиглалт. MNS 3297:1991 Хот суурин газрын хөрсний ариун Ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм хэмжээ
Усан орчин				
Унд ахуйн зориулалтаар ашиглах усны рН, TDS, нийт хатуулаг, исэлдэх чанар, Ca, Mg, Na, K, NH ₄ , нийт Fe, HCO ₃ , Cl, SO ₄ , NO ₂ , NO ₃ , амт, үнэр, өнгө, тунгалаг чанар, эрдэсжилт г.м	Уурхайн унд ахуйн хэрэглээний усыг авдаг худгаас	Жилд 1 удаа	200.0	MNS ISO 5667-1 : 2002 Усны чанар. Дээж авах 1-р хэсэг: Дээж авах хөтөлбөр боловсруулах заавар MNS ISO 5667-3 : 2019 Усны чанар. Дээж авах. 3-р хэсэг: Усны сорьцтой харьцах ба сорьцыг тогтворжуулах
Төслийг хэрэгжүүлэх эхний жилийн зардлын урьдчилсан дүн			1 000.0	

ОХШХ-ийн хүрээнд уурхай орчмоос агаарын чанарын болон хөрсний бохирдлын дээжийг жил бүр авч шинжлүүлж байна.

4.9. Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 19. Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан
			2026 он			
			4-5-р сар	6-8-р сар	9-10-р сар	
1	Уурхайн бэлтгэл ажлыг бүрэн хангах	Үйл ажиллагааны зардлаар				Уурхайн дарга
2	УАТөлөвлөгөө болон БОМТ-г боловсруулан батлуулах	-				Ашиглалтын инженер, БО-ны мэргэжилтэн
3	БОМТ-нд тусгасан ажлуудыг хэрэгжүүлэх	БОМТ-ний зардлаар				Байгаль орчны мэргэжилтэн
4	Ажилчдыг ХХАА-ны хувцас хэрэгслээр бүрэн хангах	ХАБ-ын зардлаар				Уурхайн дарга
Нийт		-				

4.10. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг

хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад

тайлагнах хуваарь

Хүснэгт 20. Төслийн төлөвлөлт, биелэлтийг тайлагнах хуваарь

№	Ажлын нэр	Хэнд	Хариуцах эзэн	Хугацаа	Зардал
1	Уурхайн үйл ажиллагаа эхлэхээс өмнө төсөл хэрэгжих талбайн өнөөгийн байдлыг танилцуулах	Сэлэнгэ аймгийн БОГ, төслийн нөлөөллийн бүсийн иргэд	Уурхайн дарга, БО-ны мэргэжилтэн	V сард	500.0 мян.төг
2	Нийт хийгдсэн ажлын хэмжээ, хийгдсэн ажлуудын тайлагнал	Сэлэнгэ аймгийн БОГ, төслийн нөлөөллийн бүсийн иргэд	Уурхайн дарга, БО-ны мэргэжилтэн	X сард	

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд 10.0 сая төгрөгийг төлөвлөж өглөө. Үүнд: Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардалд 2.0 сая төгрөг, хог хаягдлын менежментийн арга хэмжээний зардалд 1.5 сая.төг, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөнд 5.0 сая төг, ОХШХ-т 1.0 сая төг, төслийн төлөвлөлт, биелэлтийг тайлагнах ажилд 0.5 сая.төг зарцуулахаар тооцсон болно.